

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:ДГА-2019/3/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг Сайншанд сум 2018 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 99092469 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Лүндэгмаа Утас: 99026829 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn Аудитор: Б.Эрдэнэтунгалаг Утас: 99063931 Цахим хаяг: sain.audit5831@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
	2.8.2Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.25 № 1-6/364

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭМ
ЭРГЭЛТИЙН САН ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-аар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-аар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон санхүүгийн тодруулга тайлангуудыг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-аар 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

444190371

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-аг удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Т.Ган-өлзийд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС /УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019-03-10-наас 2019-03-20.-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-03-22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Сайн-Аудит ХХК-ын аудитор Н.Мягмарсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019-03-15-ны өдрийн № 25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ нь Сумдын эмнэлэг болон иргэдийг чанарын баталгаатай зайлшгүй шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслээр, боломжийн үнээр тасралтгүй хангах, эмийн тусламж үйлчилгээг чанарын өндөр түвшинд соёлтой хүртээмжтэй түргэн шуурхай хүргэж, иргэдийг эмийн мэдээллээр ханган эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэхэд оршино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эм эмнэлгийн хэрэгслээр хангах

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эм эмнэлгийн хэрэгслийн тухай
- Эрүүл мэндийн тухай
- Эрүүл мэндийн даатгалын тухай
- ХХОАТ-ын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Макс, Ориан" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 22 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 0 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр борлуулалтын орлогын 1 хувиар сонгов.

Борлуулалтын орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь орлогоороо зардлаа нөхөж аж ахуйн тооцоотой ажилладагтай холбоотой юм.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2018 оны борлуулалтын орлого 1319214,2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 13192,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь уламжлалт эрсдэл байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 16 Горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 9 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	100412.4	Тооллогын үр дүнг хэлэлцээгүй, Анхан шатны баримт дутуу
2	Төлбөрийн акт тогтоосон	2	1102.2	Цалин илүү бодсон
3	Албан шаардлага өгсөн	2	75,187.10	Шатахууны тооцоо бодоогүй, Авлага барагдуулаагүй
Дүн		6	176,701.70	

2.8.1 ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨӨС БУСАД ХЭЛБЭРЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1. Авто машины техникийн бэлэн байдлыг хангаагүй, жолоочийн тооцооны хуудсыг хөтлүүлж шатахууны нормыг хянаагүй 3981.2 мянган төгрөгийн шатахууныг зардалд бичсэн нь иж бүрэн байх, хэмжигдэхүйц байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Монгол улсын Дэд бүтцийн сайдын тушаал. Дугаар 19 “Жишиг норм батлах тухай” Хавсралт 2,5-д заасан “авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд. гэсэн тушаалын хэрэгжилтийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

2.8.1.2. Санхүүгийн тайлангийн дансны авлага 71205.9 мянган төгрөг өмнөх оноос 149 %-иар өссөн. Нийт авлагын дүнд нэг жилээс дээш насжилттай авлага 53,9 %-ийг эзэлж байгаа ба үүнээс 17303.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь үнэн зөв байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Нягтлан бодогчийн эрх, үүрэг. 20.2.6. *Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах ;* гэсэн үүргээ зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын насжилтын судалгааг нарийвчлан гаргаж, цар хүрээтэй ажил зохиож, авлага барагдуулах албан шаардлага өгөв.

2.8.1.3. Томилолтын хуудас бүрэн хөтлөөгүй, цохолтгүй, зам хоног, хооны мөнгө илүү тооцсон, тайлан гаргаагүй 7 ажилтанд 281.8 мянган төгрөгийн албан томилолт олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. 20.1.4. *Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх.* гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон 281.2 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг ажилчдын цалингаас суутгаж, төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоов.

2.8.1.4. Тайлант хугацаанд 5 ажилтанд амралтын хоног давхардуулж цалин олгосон, урьдчилгаа суутгаагүй 820.4 мянган төгрөг олгосон нь үнэн зөв байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдад илүү олгосон 820.4 мянган төгрөгийн цалинг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад асуудалгүй

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-аар нь тайлант хугацаанд эм борлуулалтаас 1319214.2 мянган төгрөг, бусад орлого 750.8 мянган төгрөг нийт 1319965.0 мянган төгрөгийн орлого олж өмнөх оноос 104.9 % -иар өссөн. Тайлант үеийн ашиг 1567,0 мянган төгрөг өмнөх оноос 86 %-иар буурсан нь цалин, шимтгэлийн зардал 12 %-иар нэмэгдсэн, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний гарз 3167.7 мянган төгрөг хүлээн зөвшөөрсөн зэргээс шалтгаалсан.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын 1, 2-р гарын үсэг зурдаг албан тушаалтан болон санхүүгийн ажилчдын тогтвор суурьшил хангалтгүй байснаас шалтгаалсан.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2018оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1.1.Илрүүлэлт-1. Тайлант оны эцэст байвал зохих нөөцийн агуулахын үлдэгдэл 74910.7 мянган төгрөгийг тоолж баталгаажуулж, тооллогын үр дүнг гаргаагүй байгаа нь бодитой оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэл

Эм, эмнэлгийн хэрэгслийн хугацаа, эргэц , чанар байдал, бэлэн байгаа эсэхэд дотоод хяналт суларснаар дутагдах, өр авлага үүсэх.

Зөвлөмж

Нөөцийн агуулахын татан авалт, олголт, чанар байдал, өртөг үнэнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. 72 дугаар зүйл. Тооллогын комисс, түүний эрх үүрэг. 4. *Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;* гэснийг мөрдөх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар.

Зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар болов.

3.1.2.Илрүүлэлт-2. Харилцах дансны интернет банкны эрхийг ашиглан анхан шатны баримтгүй, удирдлагын цохолт, шийдвэргүйгээр 57 удаагийн 23701.7 мянган төгрөгийн гүйлгээ хийж журналд бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль.13 дугаар зүйл. 13.*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.* гэснийг зөрчсөн.

Эрсдэл

Мөнгөн хөрөнгийг хууль бусаар зарцуулах, дутагдах

Зөвлөмж

Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Нягтлан бодогчийн эрх,үүрэг. 20.2.5. *дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах;* гэснийг мөрдөх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар.

3.1.3. Илрүүлэлт-3. Хугацаа нь тодорхойгүй хамтын гэрээний заалтаар бүх ажилчдад түлээ,нүүрс, халаалтын хөнгөлөлтөд нэг удаа 1800.0 мянган төгрөг олгосон нь үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэл

Тусламж, тэтгэмжийг хавтгайруулан олгосноор санхүүгийн үр дүн буурна.

Зөвлөмж. Хамтын гэрээ, хэлэлцээрийг байгуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 8.1.Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулахад дараахь зарчим баримтална:

8.1.1.ил тод байх;

8.1.2.хууль тогтоомжид нийцсэн байх; гэс нийг мөрдөх.

Зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар болов

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 07 дугаар сарын 01- ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	17,308,309.18	2,539,180.23
1.1.02	Дансны авлага	46,189,205.08	69,624,637.46
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	1,561,634.55	1,581,316.98
1.1.04	Бусад авлага		
1.1.06	Бараа материал	208,527,276.43	217,306,940.88
1.1.07	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	273,586,425.24	291,052,075.55
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.01	Үндсэн хөрөнгө	260,129,948.58	87,866,080.13
1.2.02	Биет бус хөрөнгө	199,674.13	8,462,966.67
1.2.03	Биологийн хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	260,329,622.71	96,329,046.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	533,916,047.95	387,381,122.35
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.01	Дансны өглөг	28,251,313.63	23,422,661.15
2.1.1.02	Цалингийн өглөг		
2.1.1.03	Татварын өр	348,900.30	3,570,253.40
2.1.1.04	НДШ-ийн өглөг		12,086.40
2.1.1.08	Урьдчилж орсон орлого		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	28,600,213.93	27,005,000.95
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	28,600,213.93	27,005,000.95
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.01	Өмч -төрийн	189,682,669.33	189,682,669.33
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	147,906,082.04	1,556,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	167,727,082.65	167,727,082.65
2.3.09.01	Тайлант үеийн ашиг		1,410,369.42
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	505,315,834.02	360,376,121.40
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	533,916,047.95	387,381,122.35

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого /цэвэр/	1,256,616,489.31	1,319,214,235.97
2	Борлуулалтын өртөг	824,244,809.55	893,805,215.58
3	Нийт ашиг /алдагдал/	432,371,679.76	425,409,020.39
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	519,879.09	750,808.26
8	Бусад орлого	13,000,000.00	
10	Орлогын дүн	13,519,879.09	750,808.26

Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ –ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

9	Борлуулалт, маркетингийн зардал	295,075,827.32	298,447,321.84
10	Ерөнхий ба удирдлагын зардал	112,186,279.98	112,894,421.18
11	Санхүүгийн зардал	0.00	-
12	Бусад зардал	1,259,902.00	10,083,260.61
12.1	Зардлын дүн	408,522,009.30	421,425,003.63
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний/гарз/		3,167,747.61
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/		
17	Бусад ашиг /алдагдал/		
17.1	Олз, гарзын дүн		3,167,747.61
18	Татвар төлөхийн өмнөх ашиг	37,369,549.55	1,567,077.41
19	Орлогын татварын зардал	3,736,955.00	156,708.00
20	Татварын дараах ашиг /алдагдал/	33,632,594.55	1,410,369.41
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг /алдагдал/		
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	33,632,594.55	1,410,369.41
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	мөнгөн орлогын дүн (+)	1,366,026,248.16	1,455,509,681.34
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,155,211,256.07	1,294,434,505.33
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	197,295,113.00	160,324,367.75
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	13,000,000.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	519,879.09	750,808.26
1.2	Мөнгөн зарлагын дүн(-)	1,360,793,614.85	1,458,701,305.29
1.2.1	Ажиллагчдад төлсөн	279,759,546.02	289,071,682.12
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	30,660,084.43	34,698,284.28
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	842,608,990.62	1,013,627,234.35
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	23,992,752.40	21,951,533.13
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,673,158.75	23,798,365.10
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	160,329,477.39	47,981,307.39
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	10,769,605.24	27,572,898.92
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,232,633.31	-3,191,623.95
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн(-)	21,798,681.82	11,577,505.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	21,798,681.82	11,577,505.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		

Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ –ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн(-)	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	0.00
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-16,566,048.51	-14,769,128.95
5	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,874,357.69	17,308,309.18
6	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,308,309.18	2,539,180.23

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	189,682,669.33	147,906,082.04	139,360,060.75	476,948,812.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		-5,265,572.65	-5,265,572.65
Залруулсан үлдэгдэл	189,682,669.33	147,906,082.04	134,094,488.10	471,683,239.47
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		33,632,594.55	33,632,594.55
2017 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	189,682,669.33	147,906,082.04	167,727,082.65	505,315,834.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-			0.00
Залруулсан үлдэгдэл	189,682,669.33	147,906,082.04	167,727,082.65	505,315,834.02
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		1,410,369.42	1,410,369.42
Бусад дэлгэрэнгүй орлого	-			0.00
Өмчид гарсан өөрчлөлт	-	-147,906,082.04	0.00	-147,906,082.04
Дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжсэн дүн		1,556,000.00		1,556,000.00
2018 оын 12 сарын 31-р үлдэгдэл	189,682,669.33	1,556,000.00	169,137,452.07	360,376,121.40